

БАРИЛГАД ӨРЛӨГИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

20... оны сарын ... өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Нэг талаас “.....” ХХК /РД:/, түүнийг төлөөлж Төслийн албаны дарга албан тушаалтай овогтой /цаашид “Захиалагч” гэх/, Нөгөө талаас Монгол улсын иргэн овогтой /РД:...../, /цаашид “Гүйцэтгэгч” гэх, хамтад нь “Талууд” гэх/ нар нь Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон доорх нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулав.

Нэг.Гэрээний ерөнхий нөхцөл

- 1.1 Энэхүү гэрээгээр Улаанбаатар хот, Чингэлтэй дотор тоосгон ханын өрлөгөгийн ажлыг /цаашид “гэрээт ажил” гэх/ Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөв, удирдамжийн дагуу чанарын өндөр түвшинд иж бүрэн (зоорийн давхрын өрлөг ороогүй) хийж гүйцэтгэх, Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, гэрээгээр тохиролцсон журмын дагуу хөлс төлөх болон энэ гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад харилцааг зохицуулна.
- 1.2 Гэрээт ажлын чанарын баталгаат хугацаа уг барилгыг улсын комисст хүлээлгэн өгсөнөөс хойш ... жил байх бөгөөд ажлын гүйцэтгэл нь Барилгын норм, стандартын шаардлагыг хангасан байна.
- 1.3 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх бүхий албан тушаалтныг томилох бөгөөд талуудаас томилсон эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, гэрээний дагуу хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөх, гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл болохгүй.
- 1.4

Хоёр. Гэрээний хугацаа, ажил хүлээлцэх журам

- 2.1 Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажлыг 20..... оны дугаар сарын-ны өдрөөс эхлэн 20..... оны ... дугаар сарын-ний өдөр хүртэл нийт хоногийн хугацаанд хийж гүйцэтгэн захиалагч талд актаар хүлээлгэж өгнө.
- 2.2 Захиалагчаас шалтгаалан Гүйцэтгэгчийн ажил саатсан тохиолдолд гүйцэтгэгч тал тухай бүр бичгээр баталгаажуулж, Захиалагч талын Талбайн инженер болон Төслийн инженерээр батлуулах ба уг баримтыг үндэслэн ажил гүйцэтгэх графикт хугацааг хойшлуулж болно. Бусад тохиолдолд гүйцэтгэгч дээрх хугацаанд гэрээт ажлаа саадгүй хийж гүйцэтгэх үүрэг хүлээнэ.
- 2.3

Гурав. Гэрээний төлбөр, түүнийг төлөх журам

- 3.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг ажлын хөлсний дараах тарифаар тооцож гүйцэтгэнэ. Үүнд:
-.....
- 3.2 Гэрээний үнэ нийт (.....) төгрөг байх ба үүнд ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, шатны түрээс, ажлын хувцас, хөдөлмөр хамгааллын



зардал, ажил гүйцэтгэлийн хөлс, тээврийн зардал гэх мэт холбогдох бусад бүх зардал багтсан байна.

- 3.3 Захиалагч урьдчилгаа төлбөр болгон төгрөгийг нийт ажлын 15%-ийг хийж гүйцэтгэсний дараа ажлын 1 хоногт төлөх ба ажлыг 10 хоног тутамд гүйцэтгэл гаргаж, тооцоологдсон нийт гүйцэтгэлийн төлбөрийн 80 %-ийг Гүйцэтгэгчид төлнө. Ажлын гүйцэтгэлээс хамаарч дараагийн санхүүжилт хийх эсэхийг шийдвэрлэнэ.

3.....

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 Захиалагч тал:

- 4.1.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, хяналт тавих;
- 4.1.2 Ажлын гүйцэтгэлийн явцад болон ажлын гүйцэтгэлийн үр дүнг хүлээн авах үед илэрсэн чанарын аливаа доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэх;
- 4.1.3 Доголдлыг арилгуулахаар тогтоосон хугацаанд гүйцэтгэгч ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол уг доголдлыг өөрийн зардлаар арилгаж, түүнтэй холбогдсон зардлаа нөхөн төлүүлэх буюу доголдлын улмаас ажлын үр дүнгийн үнэ нь буурсан бол санхүүжилт, хөлсийг хувь тэнцүүлэн бууруулах;
- 4.1.4

4.2 Гүйцэтгэгч тал:

- 4.2.1 Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 4.2.2 Ажлыг гэрээнд заасан буюу графикт хугацаанд, батлагдсан зураг, төсвийн дагуу, чанар, стандартын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, далд ажлын актыг тухай бүр шалгуулан гарын үсэг бүхий акт үйлдэн, фото зургаар баталгаажуулах, гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл тухай бүр хөтлөх;
- 4.2.3 Ажлыг өөрөө гүйцэтгэх боломжгүй бол тухайн чиглэлээр мэргэшсэн, өндөр ур чадвартай, шаардлагатай тооны ажилтнуудаар гүйцэтгүүлэх;
- 4.2.4

Тав. Талуудын хариуцлага

- 5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцна.
- 5.2 Гүйцэтгэгч тал гэрээнд заасан хугацаанд захиалагч талд ажлын үр дүнг хүлээлгэж өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 %-иар тооцож захиалагч талд алданги төлнө.
- 5.3 Захиалагч тал гэрээнд заасан хуваарийн дагуу ажлыг гүйцэтгэсээр байхад ажлын хөлс, санхүүжилтийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.2%-иар алданга тооцож гүйцэтгэгч талд алданги төлнө.

.....
... Үргэлжлэл бий ...7х